



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/Б2

Чойр

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь заалт, “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн Татварын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэст тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилган, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Татварын газрын дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг)-т үүрэг болгосугай.
5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг)-т даалгасугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Г.Наранбаяр)-т даалгасугай.



Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJIL\TUSHAAL.doc

008010142

Хавсралт №Б1

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэний жагсаалт

№	Нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн нэр	Хандив өгсөн иргэний овог нэр	Хандивын дүн, төгрөгөөр УГА0855 9019049
1	Ардчилсан нам	И.Мөнхбат	Ц.Ариунаа	1,000,000.00
2	Ардчилсан нам	И.Мөнхбат	Бат-Энх	1,000,000.00
3	Монгол Ардын нам	Ц.Энхжаргал	Д.Оюунбилэг	1,000,000.00
4	Монгол Ардын нам	Г.Эрдэнэбаатар	Г.Анхбаатар	1,000,000.00
5	Монгол Ардын нам	Т.Түмэнбаяр	Б.Энхболд	1,000,000.00
6	Монгол Ардын нам	Э.Амарсайхан	Ч.Цолмонбаатар	1,000,000.00
7	Монгол Ардын нам	Т.Бат-Эрдэнэ	Т.Тамир	1,000,000.00
8	Монгол Ардын нам	Б.Отгонсүрэн	Ц.Мөнхпүрэв	1,000,000.00
9	Монгол Ардын нам	Б.Наранбаатар	Б.Наранзул	1,000,000.00
10	Монгол Ардын нам	Г.Батзам	Х.Баярцэнгэл	1,230,000.00
11	Монгол Ардын нам	Б.Ариунболор	С.Сүүндэг	1,060,000.00
12	Монгол Ардын нам	Б.Анхбаяр	Б.Сосорбурам	1,000,000.00